

**ХӨСӨГ ТРЕЙД ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 05 сарын 18-ны дөр

Дугаар: 2019/1

Улаанбаатар хот

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлыг 2019 оны 5-р сарын 18-ний өдрийн 12.00 минутанд Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж компанийн өөрийн байранд болов.

ХУРЛЫН ИРЦ:

Хувьцаа эзэмшигч:

Д.Нямбаяр	89,242	ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Цэгмид	51,830	ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Л.Мягмаржав	3,870	ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Б.Анхбаяр	60,145	ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
Ч.Батмөнх	29,697	ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр Б.Анхбаяр/
Д.Халтар	44,824	ширхэг хувьцааны саналаар /итгэмжлэлээр Э.Долгорсүрэн/

Нийт 279,608 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 94,53 % хувийг эзэмшигчид хуралд хүрэлцэн ирэв. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд болох Б.Төрсайхан, Д.Цэвээнцэрэн, Д.Бямбажал нар хуралд биечлэн оролцов.

Тооллогын комиссын гишүүн Ц.Хүрэлбаатар хуралд биечлэн хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн болон итгэмжлэлээр оролцогчдын итгэмжлэл болон бичиг баримтуудыг нягтлан шалгаж, хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Тооллогын комиссын тогтоолоор хурлын ирц 94.53% хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1-д заасаны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг 12:20 цагт эхлүүлэв.

Хурлыг хувьцаа эзэмшигч Л.Мягмаржав даргалав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Компанийн 2018 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын хэмжээг тогтоох;

СОНССОН НЬ:

Хурлыг даргалагч Л.Мягмаржав, 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 4-р сарын 27-ны өдөр товлөгдож, зарлагдсан боловч зарим хувьцаа эзэмшигчдэд хүндэтгэх шалтгаан гарч, биечлэн ирээгүйн улмаас хурлын ирц хүрэлцэхгүй болж хойшилсон тухай болон ийнхүү хойшилсон хурлыг Компанийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу дахин зарлаж, өнөөдөр хуралдаж байгааг дурьдаж, хэлэлцэх асуудлуудыг уншиж танилцуулав.

1-р асуудлаар: 2018 оны үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Д.Нямбаяр уншиж танилцуулав.

Санхүүгийн үйл ажиллагааны тайланг компанийн Ерөнхий нягтлан бодогч Н.Одмаа уншиж танилцуулав.

2018 онд ногдол ашиг хувиарлахгүй байх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг ТУЗ-ийн дарга (хуучин) Л.Мягмаржав уншиж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан хувьцаа эзэмшигч Б.Анхбаяр компанийн эд хөрөнгийг түрээслэж байгаа үйл ажиллагаанд гарч байгаа зөрчилүүд болон компанийн газар дээр баригдсан бусдын зарим үл хөдлөх хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх гэж байгаа талаар Гүйцэтгэх удирдлагаас асуулт асууж, эдгээр нь үйл ажиллагааны орлогод муугаар нөлөөлж, улмаар ноогдол ашиг тараахгүй байгаа талаар шүүмжлэл хэлж, гүйцэтгэх удирдлагаас хариулт авав.

Хувьцаа эзэмшигчдээс Б.Анхбаярын гаргасан санал шүүмжлэлийн дагуу цаашид тус компанийн хөрөнгүүдийн үр өгөөжийг сайжруулах, компанийн газар дээрх бусдын хөрөнгүүдийн талаар холбогдох арга хэмжээг авах талаар шинээр зохион байгуулагдах ТУЗ үйл ажиллагаандаа анхаарч ажиллах, Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, шахаж, шаардаж ажиллах нь зүйтэй гэж тогтов.

2-р асуудлаар: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн анкетаас товч мэдээлэлийг хурлыг даргалагч Л.Мягмаржав танилцуулав.

ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид:

Л.Мягмаржав
Д.Бямбажал
Л.Цэгмид
Д.Сугаржав
Д.Нямбаяр
Б.Анхбаяр
Ч.Батмөнх

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид:

Ц.Монгол
Д.Цэвээнцэрэн

С.Мөнхгэрэл
О.Шинэбаяр
Б.Төрсайхан
Ц.Оюунтуяа

3-р асуудлаар: ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг:

- ТУЗ-ийн дарга даргын цалин, урамшуулал – 450 000 төгрөг,
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал – 320 000 төгрөг,
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга цалин – 450 000 төгрөг гэж тус тус тогтоох саналыг хурал даргалагч танилцуулж,

Мөн, цаашид улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдвөл ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин урамшуулал дагаж өөрчлөгдөх асуудлуудыг тухай бүр ТУЗ-өөр хэлэлцүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэдэгт хувьцаа эзэмшигчид санал нэгдэв.

Хувьцаа эзэмшигч Б.Анхбаярын зүгээс ТУЗ-ийнхэнд ажлын өрөө гаргах, бичиг цаасны зардалтай байх санал гаргасныг хувьцаа эзэмшигчид дэмжээд, ТУЗ-ийн хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өрөө тасалгааны асуудлыг хэрхэн шийдвэрлэх болон хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай төсвийг хэлэлцэж батлах эрхийг шинээр байгуулагдах ТУЗ-д өгөх нь зүйтэй гэдэгт санал нэгдэв.

Хэлэлцэх асуудлын танилцуулга дуусав.

Тооллогын комиссоос Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд тусгагдаж, хурлаар хэлэлцэгдсэн асуудлуудаар санал авах саналын хуудсыг тарааж өгөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудлаар өгсөн санал болон ТУЗ-ийн ердийн 6, хараат 3, нийт 9 гишүүнийг сонгох асуудлаар кумлятив аргаар өгсөн санал бүхий саналын хуудсыг тоолж дүнгээ гарган, уншиж танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2018 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.

3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Б.Анхбаяр
Ч.Батмөнх
Д.Бямбажал
Л.Мягмаржав
Д.Нямбаяр
Л.Цэгмид

4. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

С.Мөнхгэрэл
Ц.Оюунтуяа
Б.Төрсайхан

5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын нэг сарын цалин урамшуулалыг хавсралт № 01-д дурьдсанаар баталсугай. Үүнд:

- ТУЗ-ийн даргын цалин - 450 000,
- ТУЗ-ийн гишүүдийн цалин - 320 000,
- ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин - 450 000 төгрөг
- Цаашид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн тохиолдолд ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин урамшуулал дагаж өөрчлөгдөх асуудлуудыг тухай бүр ТУЗ-өөр хэлэлцүүлж шийдвэрлэх,

6. Батлагдсан төсвийг дагуу цалин урамшуулалыг бодож олгохыг нягтлан бодогчид даалгасугай.

7. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Компанийн шинээр бүрдсэн ТУЗ-ийн анхны хурлыг 2019 оны 5 дугаар сарын 26-ны өдөр хуралдуулахаар тогтов

Хурал 15 цаг 30 минутанд өндөрлөв.

(хурлын аудио бичлэгийг хадгалав)

ХУРЛЫН ДАРГА

/ Л.МЯГМАРЖАВ/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

/ А.АРИУНСАЙН /

